

ГАРЧИГ

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт, горим	4
1.3. Ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт.....	5
1.4. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц.....	6
1.5. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	7
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	8
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	10
3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	10
3.2. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим.....	13
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	15
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
4.6. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	21
4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал.....	22
4.8. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	23
4.9. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	24
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	25

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	3
Хүснэгт 2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	4
Хүснэгт 3. Уурхайд ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт	5
Хүснэгт 4. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	10
Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах	12
Хүснэгт 6. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл.....	13
Хүснэгт 7. Гол сөрөг нөлөөлөл.....	14
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	16
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 11. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 12. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 13. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 15. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	23
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	24
Хүснэгт 17. Олон нийтийн оролцоог хангах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо.....	25

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн топо зураг 1:50000.....	3
---	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Пауэрлэнд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011247064, Регистрийн дугаар: 2843129, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-021718


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19-р хороо, 4-р хороолол, 54-13 тоот. Утас: 9911-7481

Төслийн байршил: “ПАУЭРЛЭНД” ХХК-ийн эзэмшдэг MV-021718 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Алагтолгойн чулуун нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төвөөс баруун хойш 28 км, УБ- Сайншанд төмөр замын 25-р зөрлөгөөс 24 км зайд оршино.

Талбайн солбицлын цэгүүд:

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

Д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ, га	Өргөрөг			Уртраг		
			Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	MV-021718	1278.63	46	11	01.64	109	02	10.7
2			46	10	16.64	109	02	10.7
3			46	10	16.66	109	03	01.71
4			46	08	01.65	109	03	01.71
5			46	08	01.65	109	01	01.71
6			46	11	01.64	109	01	01.71



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн топо зураг 1:50000

1.2. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт, горим

1.2.1. Уурхайн жилийн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадлыг 2023 онд сард 20 мян.тн, жилд 200 мян.тн нүүрс олборлоно гэж төлөвлөгөөнд тусгалаа.

Хүснэгт 2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Д/д	Үзүүлэлтүүд	Нэгж	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Нийт
Ил уурхайн ажил							
1	Олборлолтын хэмжээ	мян.м ³	14.6	51.0	51.0	36.8	153.39
2	Ашигт малтмалын нягт	кг/ м ³	1.37	1.37	1.37	1.37	1.37
3	Олборлолтын хэмжээ	мян.тн	20.0	70.0	70.0	50.5	210.45
4	Хөрс хуулалтын хэмжээ	мян. м ³	400.0	702.3	695.9	309.1	2107.29
7	Шимт хөрс хуулалтын хэмжээ	мян. м ³	1.0	7.2	11.0	-	19.21
8	Нийт уулын цул	мян. м ³	415.6	760.5	757.93	345.85	2279.89
10	Хөрс хуулалтын дундаж коэффициент	тн/ м ³	20.05	10.14	10.10	6.13	10.10
Хөрсний овоолго байгууламж							
1	Гадаад овоолгын хэмжээ	мян. м ³	424.00	744.48	516.34	0.00	1684.81
	Сийрэгжилтын хэмжээ		1.06	1.06	1.06	1.06	1.06
2	Дотоод овоолгын хэмжээ	мян. м ³	0.00	0.00	221.29	366.60	587.89
	Сийрэгжилтын хэмжээ		1.06	1.06	1.06	1.06	1.06
3	Шимт хөрсний овоолгын хэмжээ	мян. м ³	1.18	8.47	13.03	0.00	22.67
	Сийрэгжилтын хэмжээ		1.18	1.18	1.18	1.18	1.18
Уулын ажлын хэмжээ өсөх нийлбэрээр (уулын цулаар)							
1	Нүүрс олборлолт	мян.тн	20.00	90.00	160.00	210.45	210.45
2	Хөрс хуулалт	мян. м ³	400.00	1102.34	1798.21	2107.29	2107.29
3	Шимт хөрс хуулалт	мян. м ³	1.00	8.17	19.21	19.21	19.21

1.2.2. Уурхайн ажиллах горим

Тус уурхай нь жилийн баяр ёслол, амралтын өдрүүдээс бусад бүх өдрүүдэд хөдөлмөрийн хуулийн дагуу ажиллана.

Жилд ажиллах хоногийн тоо:

- ✓ Жилийн нийт хоног – 365
- ✓ Жилд ажиллах хоног – 315
- ✓ Амралт, баяр ёслолын хоног – 11
- ✓ Урсгал засвар хийх өдрүүд – 24
- ✓ Цаг агаарын саатал – 15
- ✓ Ээлжийн тоо – 2 ээлж
- ✓ Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа – 12 цаг

1.2.3. Уурхайн талбайг ашиглах дараалал

Ордыг ашиглах. Хөрс хуулалт, олборлолтын ажил эхлэхийн өмнө үржил шимт хөрс буюу гадаргаас ойролцоогоор 0.4 м орчим зузаантай хэсгийг бульдозероор хуулж экскаватор автосамосвалын хослолоор тээвэрлэн ашиглалтын талбайд саад болохооргүй зайд түр овоолго үүсгэнэ.

Энэ нь нөхөн сэргээлт хийх ажлын төгсгөлд үржил шимт хөрсөөр буцаан хучих нөхцөлийг хангаж өгнө. Алагтолгой хэсгийн чулуун нүүрсний уурхайн хувьд ил уурхайн гүн 38 м хүрч гүнзгийрнэ. Хөрсний чулуулаг нь аргиллит, элсэн чулуу зэрэг голдуу дунд зэрэг бөх чулуулагтайд хамаарагдах хөрстэй тул ажлын бус доголын налууугийн өнцгийг 55⁰ байхаар сонгож авав.

1.3. Ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт

1.3.1. Ашиглалтын системийн сонголт

Алагтолгойн уурхайн нүүрсний давхаргын тогтоц, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн хатуулаг болон бусад уул-техникийн нөхцөлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор - автосамосвалын хослолоор гүйцэтгэхээр тээвэртэй ашиглалтын систем сонгож авав.

Хөрсийг гадаад овоолгод, нүүрсийг Олон-Овоогийн төмөр замын 25-р зөрлөг рүү тус тус тээвэрлэнэ.

1.3.2. Уулын үндсэн ажилд хэрэглэгдэх тоног төхөөрөмжүүд

Уурхайд хэрэглэх тоног төхөөрөмж, техникийг сонгохдоо тус ордыг ашиглах өмнөх ТЭЗҮ-г үндэслэн тус төсөлд сонгосон техникүүдийг ашиглахаар тооцлоо. Үүнд: Уурхай дээр хөрс хуулалт, олборлолтонд 1.3 м³ багтаамжтай шанага бүхий урвуу утгууртай Хьюндай (Hyundai R210LC-7) маркийн экскаватор, хөрс болон нүүрс тээвэрлэлтэнд Хятад улсад үйлдвэрлэдэг 25 тн-ын даацтай Хово (Howo) маркийн автосамосвал, нүүрсний гадаад тээвэрт дунджаар 24 км тээвэрлэхэд 40 тн-ын даацтай мөн Хятад улсад үйлдвэрлэдэг Хово (Howo) маркийн автосамосвал, өрөмдлөгийн ажилд KQG-120Y маркийн өрмийн машин, овоолгын хөрс түрэлтэнд Хятад улсад үйлдвэрлэсэн Эс Ди (SD-23) маркийн бульдозер, уурхайн нөхөн сэргээлт, зам засварлах зэрэг туслах ажлуудад Хятад улсад үйлдвэрлэдэг PY-200 маркийн грейдерийг ашиглахаар ТЭЗҮ-н тодотгол тооцоонд тусгасан болно. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжийг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Уурхайд ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Шаардлагатай тоо
Ил уурхай			
1	Экскаватор	Hyundai R210LC-7	3
2	Авто самосвал /хөрс/	HOWO	4
3	Авто самосвал /нүүрс/	HOWO	1
4	Авто самосвал /гадаад тээвэр/	HOWO	4
5	Өрмийн машин	KQG-120Y	1
6	Бульдозер	Shantui SD23	1
7	Утгуурт ачигч	ZL-50	1
8	Авто грейдер	PY-200	1
9	Зам усалгааны машин	-	2

1.4. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

Ил уурхайд жилд дунджаар 110 хүн ажиллах юм. Нэг бригад 21 хоног ажиллаад 7 хоног амарч байхаар горим төлөвлөсөн. Үйлдвэрийн ажиллагсдыг Даланжаргалан сумын ард, иргэдээс хангах боломжтой. Уурхайд иргэний ба үйлдвэрлэлийн доор тусгасан барилга байгууламжууд баригдана.

Үйлдвэрлэлийн барилга байгууламж

Тус уурхайд бага оврын засвар, үйлчилгээний газар, контор, ахуй үйлчилгээ-халуун ус, дулаан гараж, уурын зуух г.м барилга байгууламжуудыг барихаар төлөвлөв. Барилга байгууламжийн нэр, хэмжээ, зардлыг одоо үед байгуулагдаж буй жижиг уурхайнуудын барилга байгууламжийн жишгээр гаргаж ТЭЗҮ-д тусгав.

Ажилчдын барилга байгууламж

Ажиллагсдын ахуйн хангамж орон сууцанд зориулж барилга байгууламжийг барихаар төсөлд тусгаж, тосгоны барилга байгууламжид 162.0 сая төг, уурхайн нийт барилга байгууламжуудад нийт 770.0 сая.төг хэрэгцээтэй байна.

Шатах тослох материалын агуулах.

Уурхайд жилд дизелийн түлш 500-797 тн, дизелийн масло 100-159 тн-ыг тус тус хэрэглэнэ. ШТМ-ыг 1 сарын нөөцтэй байхаар бодож түлшинд 20 тн-ыг хадгалах багтаамжтай ган сав 2 ш -ийг, бензинд 5 тн - ын багтаамжтай ган сав 1 ш, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгалахаар төсөлд тусгав.

ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

Автогараж.

Уурхайн хөрс тээвэрлэлтэнд нийт 4 машин, нүүрс тээвэрлэлтэнд 4 машин ажиллах ба уг машинуудыг засварын цехийн дэргэд ил зогсоолд байрлуулна. Уурхайн бусад ажилд суудлын машин 1, ачааны машин 1, үйлчилгээний машин 1, усны машин 1, усалгааны машин 1, шатахууны машин 1 нийт 6 машин байна. Эдгээр машинуудад зориулж 5 машины дулаан гараж нэгийг барихаар төсөлд тусгав.

Сэлбэг материалын агуулах.

Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материалын агуулахад зориулж дулаалга бүхий 20 тн -ын контейнер 1 ш -ийг төсөлд тусгав.

Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны гол хэрэглэгчид нь өрмийн машин, ил уурхайн цахилгаан гэрэлтүүлэг болон ажилчдын хотхон, засвар механикийн цех, уурхайн захиргаа зэрэг хэрэглэгчид байх юм. Тус уурхай нь Элдэвийн нүүрсний уурхайтай зэргэлдээ орших учир уурхайн хэрэглэгчдийг Элдэвийн уурхайн хэрэглэгчид тэжээгдэж байгаа

Даланжаргалан сумын төвөөс татагдсан 10 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамнаас салбарлуулан 6/0.4кВ-ын бууруулах трансформаторын дэд станцаар дамжуулан уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахаар тусгав. Цахилгаан хангамжийн эх үүсвэрт АС-25 маркийн утастай 10 кВ-ын агаарын шугам, КТП-250 төрлийн 10/0.4 кВ-ын трансформаторын иж бүрэн дэд станц, 0.4 кВ-ын кабель болон агаарын шугамыг ашиглах бөгөөд нийт 117.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Ус хангамж

Усны эх үүсвэр

Уурхайн унд ахуйн хэрэгцээний усыг өрөмдмөл худгаас, харин технологийн усыг уурхайн шүүрлийн усаар тус тус хангана.

Уурхай жилд нийтдээ 315 хоног үйл ажиллагаа явуулах бөгөөд нийт 110 хүн ажиллана. Ажилчдын унд болон ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээг стандартын дагуу 1 хүнд хоногт 20 л байхаар тооцлоо.

Уурхайн усан хангамжийг төслийн талбайд гаргах гүний худгаас хангахаар төлөвлөлөө.

Технологийн болон ундны усны хэрэгцээ

Ахуйн хэрэгцээнд:

- ✓ 1 хүнд ноогдох усны хэмжээ, хоногт - 20 л
- ✓ Ундны усны нийт хэрэгцээ: 110 хүн х 315 хоног х 20 л = 693000 л = 693.0 м³

Технологийн хэрэгцээний ус:

Уурхайн олборлолтын явцад технологийн ус ашиглагдахгүй боловч тоосжилтыг дарах зорилгоор зам усалгаанд 700.0 м³ ус зарцуулахаар төлөвлөлөө.

1.5. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2023 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 200.0 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газрын гадарга

Алагтолгойн чулуун нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төвөөс 28 км, УБ- Сайншанд төмөр замын 25-р зөрлөгөөс 24 км зайд оршино.

Физик газарзүйн хувьд газар зүйн мужлалаар Төв азийн геоморфологийн их мужид түүний дотор Дундговь - Дорноговийн мужийн Мандалговь-Сайншандын дүүрэгт хамаарагдах учир газрын гадаргуугийн ихэнхи хэсэг нь гүвээ, жижиг толгод бүхий тэгшивтэр өндөрлөг зонхилох ба далайн төвшнөөс дээш 1100-1200 м өргөгдсөн байдаг. Талбайн усан хагалбар болох нам уулс гүвээ нь өргөрөгийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн дүүргийн тектоник эвдрэлийн чигтэй давхацдаг.

Цаг уур

Даланжаргалан сум нь хүйтэн, хуурай урт өвөл, харьцангуй чийглэг богино зунтай эх газрын эрс тэс уур амьсгалтай, 7 дугаар сард дундаж хэм $+25.0^{\circ}\text{C}$ дулаан, 12 дугаар сард -21.0°C хүрч хүйтрэх ба хүйтний хугацаа 2 сар үргэлжилдэг, цаг уурын Дорнодын мужид хамаардаг.

Усан орчин

Алагтолгойн хэсгийн үнэмлэхүй өндөр нь 1250-1300 м, харьцангуй өндөр нь 19 м. Нүүрсний давхаргууд нь гадаргуугаас 50 м хүртэл гүнд доод цэрдийн уст тунамал чулуулгийн уст бүрдлийн хүрээнд байрлана.

Гидрогеологийн судалгаагаар хийсэн шавхалт туршилтын ажлын үр дүнгээс харахад ордын хүрээнд усны тогтонги түвшин нь 12.3-25.1 м-ийн гүнд байрлах ба ерөнхийдөө хойноос урагш гадаргуугийн үнэмлэхүй өндөр намссанаар усны түвшин дээшилдэг. Алагтолгойн хэсгийн талбайд тархсан чулуулгийн усжилт жигд биш, хэсгийн янз бүрийн хэсгүүдэд өрөмдсөн гидрогеологийн цооногуудын ундарга 0.3-2.1 л/с байх ба хэсгийн хойд хэсэгт төв, өмнөд хэсгээсээ харьцангуй илүү усжилттай.

Хөрсөн бүрхэвч

Даланжаргалан сумын хувьд нутгийн зүүн болон төвийн хэсгээр нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрс тархсан. Харин нутгийн өмнө болон зүүн урд хэсгээр нунтаг карбонатлаг хүрэн хөрс, хойд болон баруун хэсгээр нунтаг карбонатлаг хар хүрэн хөрс, тус тус зонхилон тархсан байна. Уурхай орчимд толгодын нимгэн цайвар хүрэн болон сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс тархсан байна.

Ургамлан нөмрөг

Даланжаргалан сумын нутгийн ихэнх хэсгээр тэгш тал, нам уулсын дэгнүүлт үетэнт хуурай хээр бүлгэмдлийн чулуусаг-алаг өвс-шивээт хялганат хээр, хойд болон төв, урд хэсгээр харгана-жигжиг дэгнүүлт үетэн-шивээт хялганат зарим газар нь Зүүнгарын хазаар өвс- өдлөг хялганат, агь хялганат үетэн-шивээт хялганат зарим газар нь Зүүнгарын хазаар өвс- өдлөг хялганат, агь-хялганат, алтан ба ямаан харгана тархсан.

Амьтны аймаг

Судалгааны талбай орчмын нутгаар цөлөрхөг хээрийн амьтад тархсан. Үүнд мэрэгчдээс бозлог, алаг даага, орог зусаг, элсний зусаг, шар чичүүл, атигдаахай зэрэг амьтад элбэг, цагаан зээр элбэг, хар сүүлт ховор, махчин амьтнаас үнэг, хярс, мануул, өмхий хүрэн, жигүүртнээс тас, элээ, тоодог, харцага, болжмор, ногтруу мөн олон төрлийн шавьжнаас цох, царцаа, хөх түрүү, хар ялаа, хачиг, мухар ялаа элбэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 4. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Ург хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x				x		x	x		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x			x					x
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал		x			x		x			x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x				x		x	x		
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			x
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x			x
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x			x			x
Хүчтэй салхи, уруйн үер										
Дүн	17	3		1	19		19	5	6	9

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо *магадлан жагсаах* аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
1.Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				х
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				х
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		х		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				х
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			х	
4.Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			х	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			х	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		х		
5.Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

3.2. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

“Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн хүрээнд нүүрс олборлох, ухаж ачих, тээвэрлэх үйл ажиллагаанууд хийгдэнэ. Ийм ил уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг авч үзэхдээ Леопольдын матрицын аргыг хэрэглэв. Энэ нөлөөллийн чухал байдлын зэрэглэл ба нөлөөллийн болзошгүй утгыг 1-10 хүртэл оноогоор нилээд дэлгэрэнгүй байдлаар тодорхойлов. Ийнхүү үнэлгээ өгөхдөө аль болохоор бодит байдалд тулгуурласан нарийн мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтийг үндэс болголоо. Леопольдын матрицын арга нь дараах 3 үйлдэл хийхийг шаарддаг. Үүнд:

- ✓ Хэрэв экологийн тогтолцоонд төслийн технологийн үе шатны аль нэг үйл ажиллагаа нь нөлөөлөхөөр байвал түүнд харгалзах дөрвөлжинг ташуу зураасаар 2 хуваана.
- ✓ Хуваагдсан хэсгийн доод талд болзошгүй нөлөөллийн чухал байдлыг 1-10 хүртлэх тоогоор үнэлнэ.
- ✓ Хуваагдсан хэсгийн дээд талд мөн 1-10 хүртлэх оноогоор болзошгүй нөлөөллийн хүчтэй эсэхийг үнэлэн бичнэ. Үүнд: 1 балл бол үнэлгээний хамгийн бага, 10 нь хамгийн их утга юм.

Хүснэгт 6. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

№	Үйл ажиллагааны хэлбэр Экологийн тогтолцоо	Эрэл хайгуул	Хөрс хуулах (хогхоны барилга, байгууламж)	Тэсэлгээ	Нүх, карьер ухах	Овоолго	Ачих тээвэрлэх	Бүгд
1	Агаар		2/3	9/9	8/8	3/3	4/5	26/28
2	Хөрс		2/5	10/10	10/10	6/6	2/3	30/34
3	Гадаргын ус							
4	Газрын доорхи ус							
5	Ургамал		5/5	9/9	9/9	8/8	2/3	33/34
6	Ан амьтан		1/1	1/1	2/2		1/3	5/7
7	Усны амьтан, ургамал							
8	Геологийн тогтоц		1/1	9/9	3/3		1/1	14/14
9	Байгалийн үзэсгэлэн		1/1	5/5	4/4	1/1		11/11
10	Бэлчээр		2/2	5/5	8/8	6/6	1/1	22/22
11	Хүний эрүүл мэнд		5/6	4/5	5/6	1/2		15/19
12	Бүгд		19/24	52/53	49/50	25/26	11/16	156/169

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүх, карьер ухах, овоолго хийх, ачих тээвэрлэх явц нь агаар, хөрс, ургамал, хүний эрүүл мэнд зэрэгт ихээхэн нөлөөлж болзошгүй нь харагдаж байна.

Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, ургамал зэрэг юм.

Нөлөөлөлд орох байдлаар ангилбал агаар 26/28, ургамал 33/34, хөрс 30/34, бэлчээр 22/22 1-р ангилалд, геологийн тогтоц 14/14, хүний эрүүл мэнд 15/19 2-р ангилалд орж байна. Иймд 1 ба 2-р ангиллын өртөгчдөд нарийвчилсан судалгаа, тооцоо хийх нь зүйтэй.

Хүснэгт 7. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхайн үйл ажиллагаа болон овоолгоор хөрс, ургамал нь бүр мөсөн устаж, дахин сэргээгдэхгүйгээр үхжинэ.
2	Агаар	Нүүрсийг ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
3	Ургамал	Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- ✓ Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- ✓ БОННҮ нэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн гол болон тээврийн зам	км	50.0	5.0	250.0 x 20 удаа = 5 000.0	Зуны хуурай улиралд 7 хоногт 2 удаа	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	ш	200.0	4	ОХШХ-ийн зардлаас	Жилд 2 удаа	
Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Уурхай	Үйл ажиллагааны зардлаас			ОХШХ-ийн зардлаас	Жил бүрийн эхэнд	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх		Үйл ажиллагааны зардлаас				Үйл ажиллагааны турш	
3		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	ш	50.0	4	Улиралд 1 удаа		
Хөрсөн бүрхэвч									
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Овоолго	Үйл ажиллагааны зардлаас			Ашиглалтын явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны	
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Шимт хөрсний овоолго						

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу						ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”
Газрын хэвлий									
1	Нүүрс олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Карьерын хананд хэвгийгүйжилт хийж гулсалт нурултгүй болгон, урсгал усны үйл ажиллагааны нөлөөллөөр элэгдэл эвдрэл үүсэхээргүй болгон тогтвортой байдлыг хангах байдлаар техникийн нөхөн сэргээлт хийх	Ил уурхай	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар			Ашиглалтын явцад	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд	
Ургамлан нөмрөг									
1	Уурхайгаас нүүрс олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолгын талбай	Ашиглалтын зардлаар			Ашиглалтын явцад	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага	
2		Уурхайн тосгон орчимд ногоон байгууламж бий болгох	Уурхайн тосгон	ш	2.0	4 000.0	Үйл ажиллагааны зардлаас	10-р сард	
Амьтны аймаг									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Үйл ажиллагааны турш		Ашиглалтын зардлаас			2023 онд	Амьтны тухай хууль: 6.1.3.амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах; 6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;
2023 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн						5 000.0			

4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	2023 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.						MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
2	Биологийн нөхөн сэргээлт							
3	Татан буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	-
Нийт								

4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Нөхөн сэргээлт	Даланжаргалан сумын Бурхант, Сээрийн булаг нэртэй 0.76 га газрыг нөхөн сэргээх, тэмдэгжүүлэх	46 03 21.57 108 51 21.84 46 03 22.79 108 51 27.71 46 03 24.64 108 51 27.06 46 03 22.49 108 51 20.30 Нийт 0.14 га 46 03 25.71 108 51 31.94 46 03 27.75 108 51 31.75 46 03 26.59 108 51 30.65 46 03 22.49 108 51 20.30 Нийт 0.05 га	0.76 га	5000.0	5 000.0	2023 онд	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд

4.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2023 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 12. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Уурхай орчимд археологийн дурсгал илрээгүй болно.						
2	Палеонтологийн дурсгал	Уурхай орчимд палеонтологийн дурсгал илрээгүй болно.						

4.6.Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Галын булан байрлуулах	Уурхайн тосгон	2	500.0	1 000.0	2023 онд	MNS 6576 : 2016 Гал түймэртэй тэмцэх. Гал түймэр унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага
		Аваар устгах төлөвлөгөө боловсруулах	Уурхай	1	Үйл ажиллагааны зардлаас			Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм
2	Тэсрэх бодис	Мэргэжлийн гэрээт байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх	Тэсэлгээний ажлын үед	Ашиглалтын зардлаас				MNS 4223 : 1994 Тэсрэх бодис Техникийн шаардлага
		Тэсрэх бодисын тоо бүртгэлийг тогтмол хийх						
		Тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан аюулгүй болгох						
Нийт		1 000.0						

4.7.Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан хадгалах цэгийг тохижуулах	Уурхай	ш	1 000.0	1	1 000.0	4-р сар	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Уурхай	сар	50.0	10	500.0	4-10-р сар	
2	Үйлдвэрийн	Шороон овоолго үүсгэн хадгалах	Уурхай	Ашиглалтын зардлаар				2023 онд	
3	Аюултай	Тэсрэх бодисын сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанид хүлээлгэн өгөх	Уурхай					2023 онд	
Нийт					1 500.0				

4.8. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			4-5-р сар	6-8-р сар	9-10-р сар		
1	Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Уурхайн дарга	
2	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-				Ашиглалтын инженер, БО-ны мэргэжилтэн	
3	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар				Байгаль орчны мэргэжилтэн	
4	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	3 000.0				Уурхайн дарга	
Нийт		3 000.0					

4.9.Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын болон дуу шуугианы хэмжилт хийх, хөрсний болон усны шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөсөн бөгөөд уг ажлыг гүйцэтгэх явцдаа нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулах шаардлагатай.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар				
SO ₂ , NO ₂ , CO, Тоос,	Уурхайн карьер, гол зам, тосгон орчим 3 цэгт	Жилд 2 удаа, хавар, намар	1 000.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлаас	MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн гол зам, тосгон орчим 2 цэгт	Жилд 1 удаа	200.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Усан орчин				
Унд ахуйн зориулалтаар ашиглах усны pH, TDS, нийт хатуулаг, исэлдэх чанар, Ca, Mg, Na, K, NH ₄ , нийт Fe, HCO ₃ , Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , амт, үнэр, өнгө, тунгалаг чанар, эрдэжилт г.м	Уурхайн унд ахуйн хэрэглээний усыг авдаг худгаас	Жилд 1 удаа	300.0	MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS ISO 5667-3 : 2019 Усны чанар. Дээж авах. 3-р хэсэг: Усны сорьцтой харьцах ба сорьцыг тогтворжуулах
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			1 500.0	

4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлдөд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 17. Олон нийтийн оролцоог хангах арга хэмжээний төлөвлөгөө

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Дорноговь аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	V сард	1 500.0 мян.төг
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Дорноговь аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	

Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үзүүлэлтүүд	Зардлын хэмжээ, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хөтөлбөр	5 000.0
2	Нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5 000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 500.0
8	Осол эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	3 000.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1 500.0
10	Олон нийтийн оролцоог хангах арга хэмжээний төлөвлөгөө	1 500.0
Нийт		18 500.0